

нөхцөл байдалд тавих хяналтыг дээшлүүлэхэд онцгойлон анхаарч зохион байгуулах нь чухал байна.

Эцэст нь онцлон тэмдэглэхэд төрийн зөв бодлого, хуулийн зөв зохицуулалт, зөв менежмент, зөв хуваарилалтыг даруйхан хийхгүй бол улс орны улс төр, эдийн засаг, экологийн аюулгүй байдалд ноцтой аюул учрах, ялангуяа их гүрнүүд, үндэстэн дамнасан корпорациудын өрсөлдөөн, зөрчилдөөнд татагдан орох магадлал өндөр байна.

ШАШИН БА ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ

Ж. Баттогтох¹

Дэлхийн шашинууд ба олон улсын харилцаан дахь тэдгээрийн үүр

Янз бүрийн шашны холбоод болон байгууллагууд дэлхийн бодлогод шууд нөлөөлж байдаг нь орчин үеийн олон улсын харилцаанд шашны хүчин зүйл ямагт байдаг нь тодорхой болж байна. Дэлхий дээр гурван шашны урсгал бий: христос, ислам болон буддизм. Дээрх шашны урсгалууд нь улс үндэстний шашнаас дээгүүр тавигдаж, дэлхийд нөлөөлөх цар хүрээ нь өргөн юм. Эдгээр шашнууд үүссэн цаг үеэс эхлэн ямар нэгэн улсын хил хязгаараас хальж нөлөөлөх болсон. Энэ үзэл нь Энэ үзэл санаа нь XX зууны 2-р хагасаас олон улсын нэгдэл холбоод үүсэж эхэлсэн тэр үеээс хүчирхэгжиж эхэлсэн.

Христосын шашин нь нэгдүгээр зуунд үүссэн бөгөөд одоо үед гурван үндсэн урсгалаас тогтоно. Үүнд-католик /ойролцоогоор 1 сая хүн шүтдэг/, протестант /ойролцоогоор 400 мянган хүн шүтдэг/, үнэн алдартны шашин /ойролцоогоор 200 мянган хүн шүтдэг/. 313 онд Ромын хаан Агуу Константин христос шашныг өөрийн улсын шашин гэж тунхагласнаар христос шашин албан ёсны шашны урсгал болсон юм. Ф.Ф.Мартенсын үзэж байгаагаар христос шашин үүсэж дэлгэрэн тархсан үеэс шашин олон улсын шинж чанартай болсон. 1054 онд анх Христос шашны сүм хийд хоёр хэсэгт хуваагдав: Үнэн алдартан ба ромын католик сүм. 16-р зууны үед Ромын католик сүмээс протестант урсгал салан гарсан. Хэдийгээр христос шашнаас олон арван шашны урсгал үүссэн ч, христос шашинтны сүм хийд болон нэгдлүүдийн үйл ажиллагааг тодорхойлдог тэдгээр шашнуудын үндсэн дүрэм журам болон ёс зүйн хэм хэмжээ нь олон улсын хэрэгт ихэнх тохиолдолд өөр хоорондоо төстэй бөгөөд нэг гарал үүсэлтэй байдаг. Энэ нь юуны түрүүнд ариун бичээст /шинэ болон хуучин гэрээнд/ шашны сургааль, зан заншил, олон улсын болон үндэсний шашны зүтгэлтнүүдий цуглаан болон мөн түүнчлэн сүм хийдийн дотоодын эрх зүйн хэм хэмжээгээр илэрдэг (каноническое право).

Протестант шашны үндсэн сургааль нь 1530 оны Аугбур, 1537 оны Шмалкадьден болон М. Лютерийн 1528 ба 1529 оны жижиг болон том сургаалиуд ба Катехизис, мөн Гейдельбергийн 1562 оны номлолууд гол эх сурвалж нь болдог байв.

Ислам (мусульман) шашин нь 7-р зууны үед Арабын улсуудад үүссэн. Уг шашныг үндэслэгч нь Аллаха бурхнаас илгээгдсэн шашны номлогч Мухаммед /570 - 632 он/ юм. Мухаммедаар дамжуулж Аллах хүмүүст Ариун номын бичвэрийг буюу Коран судрыг хүргүүлсэн гэж мусульманчууд үздэг байна.

Орчин үед Ойрхи болон Алс дорнод, Зүүн өмнөд Ази болон Африкийн 120 улсад амьдардаг ойролцоогоор 900 сая мусальманчууд бий. Хуучин Зөвлөлт Холбоот улсын газар нутаг дээр амьдарч байсан улсуудад исламын шашныг ойролцоогоор 32 сая хүн шүтдэг байна. Исламын шашин нь хоёр үндсэн чиглэлд хуваагддаг. Үүнд: суннит /800 сая гаруй хүн/, шиити /ойролцоогоор 96 сая хүн/. Мөн түүнчлэн цөөхөн харитжит шашны урсгалынхан байдаг /

¹ МУИС-ийн ОУХС-ийн багш, докторант

ойролцоогоор 300 сая/.

Буддын шашин ойролцоогоор 300 сая гаруй бишрэн шүтэгчидтэй бөгөөд Энэтхэг, Хятад, Япон, Вьетнам, Солонгос болон Азийн бусад улсуудад түгэн дэлгэрсэн байдаг. Буддын шашин нь МЭӨ 5-6-р зуунд үүссэн. Түүний үндэслэгч Будда нэрээрээ алдаршсан Сидхартха Гаутама Шакья-Муни юм. Буддын шашны номлолын үндсэнд ёс зүй болон ёс суртахууныг өндөрт тавьсанд байдаг. Уг шашинд /ламын номлолтой төвдөөс бусад газарт/ удирдлагын шинжтэй бүтцийн зохион байгуулалт байхгүй боловч тус тусдаа дотооддоо үндэсний бүлэглэлүүдийг бий болгосон. Үндэстэн ард түмнүүдийн доторх янз бүрийн буддын шашны урсгалуудын тоонд хамгийн олон сүсэгтэнтэй шашны урсгал бол Хиндугийн шашин юм /ойролцоогоор 600 сая хүн/.

Дипломат ба гадаад бодлогын дэлхийн практикаас харахад дээрх шашнуудын номлолуудын эрх зүй болон ёс зүйн хэм хэмжээ нь олон улс хоорондын болон тодорхой бүс нутгуудын улс төр болон үндэстэн нийгмийн үйл явцуудад ихээхэн нөлөөлж байна. Глобалчлаын үйл явцыг хурдасгах, мөн олон улсын харилцааны уялдаа холбоог нэмэгдүүлэх чиг хандлагатай байгаа өнөөгийн нөхцөлд шашны хүчин зүйл нь улс хоорондын харилцаа холбоо, эвсэл нэгдлүүдийг шинээр бий болгох гол хүчин зүйл болж байна. Жишээ нь: Оросын холбооны улсын “Шашны сүм хийд болон шашны байгууллагуудын эрх чөлөөний тухай” (1997 онд хүчин төгөлдөр болсон) Холбооны хуульд “үнэн алдартны сүмийн үүрэг роль Оросын ард түмний түүхийн салшгүй хэсэг гээд Оросын ард түмний түүхэн өв уламжлалын салшгүй нэг хэсэг болсон Христос, Будда, Иудизмын шашин болон өөр бусад шашнуудыг хүндэтгэнэ” гэсэн байна. Христос шашны үнэ цэнийг өргөн утгаар нь тодорхойлсон хэр хэмжээг Европын холбооны үүсэл, түүнчлэн Европын аюулгүй байдал хамтын ажилгааны Хельсинксийн бичиг баримтыг боловсруулахад авч ашигласан юм. Исламын нэгдлийн шашны зарчмууд нь исламын орнуудын олон холбоо болон байгууллагууд бий болох гол нөхцөл нь болсон. Буддын шашны ойлголт нь Ази болон Номхон далайн сав газрын улсуудын олон улсын нэгдэл холбоо эвслийн үйл ажиллагаанд нөлөөлжээ.

Хүний эрхийн асуудлуудыг чухалчилж хүний эрх, эрх чөлөөг хамгаалах явдлыг юуны өмнө голчлох тухай шашны сургаалиудын гол гол үзэл санаанаас харагдаж байдаг.

Дэлхийн шашнуудын эрх зүй болон ёс зүй, үзэл суртлын зарчмууд нь (хүний гарал үүслийн нэгдэл, бүх хүн яс угсаа, гарал үүслээс үл хамааран бурханы өмнө тэгш эрхтэй, хүчирхийллийг эсэргүүцэх, энх тайвнаар орших, бүх нийтийн сайн сайхны төлөө ямагт байх) орчин үеийн олон улсын эрх зүйг түгээмэл болгох хандлагыг, ялангуй олон улсын эрх зүйн чиглүүлэн удирдах үүргийг бэхжүүлж байна. Нөгөөтэйгүүр шашны үзэл суртлын хүчин зүйлийг идэвхжүүлэх нь мөн сөрөг талтай байна. Энэ нь шашныг голчлох, үндэс суурь болгох, исламын түрэмгийлэл, бусад шашныг үгүйсгэсэн үзэл суртал зэрэг нь олон улсын тогтвортой байдлыг алдагдуулж мэднэ.

2. Шашны байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах олон улсын эрх зүйн ойлголт болон эх сурвалжууд

Шашны болон сүм хийдийн үйл ажиллагааны олон улсын эрх зүй зохицуулалт нь анх орчин үеийн олон улсын эрх зүй үүссэн үеэс хэрэгжиж эхэлсэн. 1648 оны 10 сарын 24 өдрийн Вестфалийн энхийн гэрээнд 3 шашны сургаалиудын, үүнд кальвинист, католик, лютеран шашинтнууд эрх тэгш эрхтэй гэсэн ба сүм хийдийн эзэмшил газар ба эд хөрөнгийн хуваарилалтыг зохицуулж өгсөн байна. Түүнчлэн шашны үйл ажиллагааны эрх чөлөөг баталсан хэм хэмжээ нь Парисын энхийн гэрээ (1856.3.30), Берлиний тарктат (1878.7.13), Версалийн энхийн гэрээ (1919.6.28) болон бусад Версалийн энхийн гэрээнүүдэд (1919-1923) тусгалаа олсон байна.

Шашны болон сүм хийдийн асуудлын тухай олон улсын гэрээ хэлэлцээрүүд нь Оросын хаант засгийн үеэс онцгой байр суурийг эзэлдэг байжээ. Аль эрт Литовийн /1445 он/ агуу хаанчлалын үед Новогородын хэлэлцээрт үнэн алдартны сүм хийдийн байрлах нутаг дэвсгэр

болон католикийн шашны оролцоог хөндсөн гэрээ байсан байна. Үнэн алдартны сүм хийдийн эрх, байр суурь нь Орос, Польшийн “Мөнхийн энхийн гэрээнд” (1686.5.16) бүхэл бүтэн бүлэг болон орсон байдаг. Туркын хаанчлалын үед үнэн алдартны шашны эрх, байр суурь нь Кючук-Кайнарджийн Орос Туркийн хооронд болсон (1774.7.21) хэлэлцээрээр зохицуулагдаж байсан байна. Сүүлд нь Зөвлөлт засгийн үед Ригагийн энхийн гэрээнд (Орос, Украин болон Польш улсын хооронд хийсэн 1921.3.1 оны гэрээ) шашны эрх, эрх чөлөө, шашны зан үйлийн тухай болон гэрээнд хамрагдах газар нутагт бүрэн эрхийг нь хамгаалах тухай заагдсан хэм хэмжээ байдаг.

Шашны сүм хийдийн үйл ажиллагааны болон шашны эрх чөлөөний асуудал нь 1992 оны Оросын холбооны улс болон Польш улсын хооронд хийсэн гэрээнд, мөн Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн улсуудын хэд хэдэн баримт бичгүүдэд тусгалаа олсон байдаг.

Олон улсын харилцаанд шашны байгууллагын оролцоог зохицуулах орчин үеийн олон улсын эрх зүйн үндсэнд шашны эрх чөлөө болон шашны байгууллагын үйл ажиллагааны хэм хэмжээг баталгаажуулсан олон улсын эрх зүйн гэрээ, конвенцууд үйлчилж байна. Үүнд:

1. НҮБ-ын дүрэм
2. 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал
3. 1950 оны Хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах Европын конвенц
4. 1966 оны Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
5. 1975 оны Европын Аюулгүй байдал ба хамтын ажиллагааны төгсгөлийн баримт бичиг
6. 1965 оны Арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах бүх төрлийн хэлбэрийг устгах тухай конвенц
7. 1986 оны Шашны үзэл суртлын үндсэн дээр ялгаварлан гадуурх бүх төрлийн хэлбэрийг устгах тухай тунхаглал.

Орчин үед шашин шүтэх болон итгэл үнэмшилтэй байх тухай ойлголтыг агуулсан эрх зүйн хэм хэмжээ дээрх олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд дараах хэлбэрээр орсон байна. Тухайлбал ямар нэгэн саадгүйгээр ганцаараа болон бусадтай хамтран албан ёсоор, хувиараа шашны зан үйл, номлолоо сурталчлах гэх мэт. Энэ эрх нь хүн өөрөө шашин шүтэх эсэхээ чөлөөтэй сонгох, эс шүтэх ба ямар ч шашингүй үзэлтэй гэсэн утгатай юм.

Шашны эрх, эрх чөлөө ба шашны үйл ажиллагааг хязгаарлах явдал нь тодорхой улсын олон улсын өмнө хүлээсэн үүрэгтэй уялдаж байх ёстой ба олон улсын үндсэн зарчимд үл харшилж байх ёстой. Ийм хязгаарлалт нь улсын дотоодын хууль зүйтэй нийцэж, зөвхөн ардчилсан нийгэмд тайван байдлыг бий болгох ба нийгмийн хэв журмыг сахиулах, бусдын эрх ашиг, эрүүл мэнд, зан суртахууныг үл хөндөх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор явагдах ёстой.

Олон улсын харилцааны салбарт улс болон шашны байгууллагын уялдаа холбоог хамруулан шашны эрх, эрх чөлөө ба шашны үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн хэм хэмжээг бий болгоход 1989 оны Европын аюулгүй байдал ба хамтын ажиллагааны байгууллагын гишүүн улсуудын Венийн уулзалтын төгсгөлийн баримт бичиг чухал шийдвэрийг гүйцэтгэсэн.

Уг бичиг баримтанд хэсэгчилсэн байдлаар анх удаагаа сүмийн бие даасан бүтцийг нэгтгэх арга хэмжээний тухай заасан байдаг. Үүнд:

- Шашны байгууллага, нэгдэл холбоодод дотоодын дүрэм журамтай нь нийцсэн шашны байгууллагын эрх зүйн хэм хэмжээг бий болгох,
- Шашны байгууллага, нэгдэл холбоод дотооддоо зохион байгуулалт чөлөөтэй хийх, албан томилгоо хийх, сонгох, өөрчлөх гэх мэт бүтэц зохион байгуулалтын үйл ажиллагааг өөрийн байгууллагын дүрэм журамтай нийцүүлэн явуулах эрхтэй,
- Шашны байгууллага, нэгдэл холбоод өөр бусад шашны байгууллагуудыг, шүтлэгтэн олныг болон шашнаас ангид үзэлтнүүдийг хүндэтгэх, хүлээн зөвшөөрөх үүрэгтэй,
- Шашны байгууллага, нэгдэл холбоод өөрийн боловсон хүчнээ бэлтгэх эрхтэй,
- Шашны байгууллага, нэгдэл холбоод болон сүсэгтэн олон өөрийн сонгосон хэл дээр

шашны сургаал, номлолыг хүртэх, хэвлэх эрхтэй,

- Шашны байгууллага, нэгдэл холбоодуудад шашны ном, хэвлэл, материалыг хэвлэх, тараах, үйлдвэрлэх эрхтэй
- Шашны байгууллага, нэгдэл холбоод олон нийттэй харилцах ба ийм зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийг ашиглах эрхтэй,
- Шашны байгууллага, нэгдэл холбоод сайн үйлсийн үйл ажиллагаанд оролцох эрхтэй ба бусдаас хандив дэмжлэг хүсэх, авах эрхтэй.

Орчин үеийн олон улсын эрх зүйн системд тогтсон шашны эрх, эрх чөлөө ба шашны байгууллага, нэгдэл холбоодын олон улсын харилцаанд оролцох эрх гэх мэт хэм хэмжээ нь олон улсын харилцаанд энх тайван, тогтвортой байдлыг бий болгох гол үндэс нь болж байна.

3. Олон улсын харилцаанд оролцож буй шашны байгууллагуудын эрх зүйн байдал ба ангилал

Олон улсын шашны байгууллагууд нь өөрийн дотоод бүтэц, зохион байгуулалтын онцлог болон үйл ажиллагааны байршил, үүсэн байгуулагдсан цаг хугацаанаас шалтгаалан үндсэн гурван бүлэгт хуваагддаг. Үүнд:

- Олон улсад нэр хүндтэй шашны бие даасан засаг захиргааны нэгжтэй байгууллага /сүм хийд/. Тухайлбал: Ромын католик сүм. Төв нь Ватиканд байрладаг: Оросын үнэн алдартны сүм (ОХУ, Украин, Беларусь болон ТУХН - ийн зарим улсууд, Америк, Австри, Аргентин, Бельги, Их Британи, Герман, Латви, Эстон болон Япон, Умардын сүм хийдүүд (эдгээр шашны эрх зүйн хэм хэмжээ нь бүс нутаг болон тив дэлхийг хамран үйлчилдэг).
- Сүм хийдийн хоорондох олон улсын байгууллагууд. Тухайлбал: Сүм хийдийн дэлхийн зөвлөл, Баптистын шашны дэлхийн зөвлөл, Лютеран шашны дэлхийн зөвлөл, Дэлхийн альянсын холбоо, Пакс Кристи, бүс нутгийн шашны байгууллагууд-Европын сүмийн чуулган, Европын хамба лам нарын Европын чуулган, Африкийн сүм хийдүүдийн чуулган ба Азийн христос шашны чуулган.
- Тусгай шашны бүлэг, нэгдэл холбоодын ахан дүүс, эгч дүүсийн холбоо гэх зэрэг олон улсын түвшинд хамтран үйл ажиллагаа явуулдаг шашны байгууллагууд. Өнөөдрийн байдлаар 600 гаруй ийм шашны байгууллагууд албан ёсоор бүртгэгдсэн байдаг.

Олон улсын харилцаанд оролцож буй олон янзын шашны байгууллагуудын бусдаас ялгагдах онцлог нь олон улсын түвшинд тавьсан зорилго бодлогодоо хүрэх, дэлхийд өөрсдийн шашны үнэ цэнийг мэдрүүлэхэд оршино.

Орчин үеийн олон улсын эрх зүйд олон улсын харилцаанд оролцох шашны байгууллага, тэдгээрийн өөр бусад олон улсын байшгууллага болон улс орнуудтай харилцан уялдаатай ажиллах эрхийг тунхагласан хуулийн хэм хэмжээ бий болж байна. Үүнтэй уялдаад олон улсын харилцааны салбарт шашны байгууллагын үйл ажиллагаа тус бүрдээ өөрийн гэсэн онцлогтой явуулах гурван янзын эрх зүйн системийн тогтолцоог үүссэн: олон улсын эрх зүй, дотоодын эрх зүй, сүмийн дотоод журам. Практик дээр шашны байгууллага, нэгдэл холбоодууд нь аль нэг улсын шашны байгууллага байдаг ба тодорхой улсын дотоодын хуулинд захирагддаг ба хуулийн этгээд байна. Жишээ нь:

Шашин сүм хийд, төр хоёрыг тусгаарладаг соёлтой улс орнуудаас гадна төр шашин, сүм хийдийн нэгдлийг эрхэмлэдэг зан үйлтэй (голдуу исламын шашинтай улсууд) улс орнууд тус тус олон улсын харилцаанд оролцдог. Хэд хэдэн Европын улсуудад /Англи, Норвеги, Дани, Исланд, Грек, Финлянд, Швед, Франц/ үндсэн хуульдаа албан ёсоор тусгасан төрийн шашин байдаг. Италийн Үндсэн хуульд “төр шашин хоёр нь хоорондоо харилцан хамааралгүй оршино” гэж заасан байдаг.

Европын холбоог байгуулах Маастрихтын гэрээнд Европын холбооны гишүүн улсуудын дотор төр шашны харилцааг түгээн дэлгэрүүлэхгүй байх хэм хэмжээ орсон байдаг.

Хилийн чанадад оршдог шашны төвүүд ба шашны байгууллагуудын хооронд, шашны байгууллага хоорондын уялдаа холбоо, шашны сүм хийд ба төрийн харилцааг улс орнууд бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн үндсэн зарчимд нийцүүлэн зохицуулах

ёстой. Үүний хажуугаар шашны сүм хийд, шашны байгууллагын үйл ажиллагаа нь улсын дотоодын хууль зүйд харшилсан үйл ажиллагаа явуулаагүй тохиолдолд шашны байгууллагын дүрэм журам, сургааль, номлолын талын үйл ажиллагаанд оролцохгүй байх үүрэгтэй.

Шашны байгууллага олон улсын харилцаанд оролцохдоо бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын үндсэн зарчим болон эрх зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх ёстой ба үйл ажиллагааныхаа хүрээнд тодорхой эрх үүрэг хүлээдэг. Хэдийгээр шашны байгууллага нь олон улсын харилцаанд оролцож эрх үүрэг хүлээдэг ч олон улсын эрх зүйд хууль зүйн чадамжгүй этгээд ба өөрөөр хэлбэл олон улсын эрх зүйн субъект болж чадахгүй. Энэ нь Ромын католик сүмд хамаарах бөгөөд түүний удирдлагын төв болох Ватикан нь олон улсын эрх зүйн үүсмэл субъект болж болно.

Шашны нэгдэл холбоо, байгууллагууд нь улс хоорондын гэрээ хэлцлээс хамаарахгүйгээр олон улсын харилцаанд оролцох, зохион байгуулах боломжтой байдаг. Тэдгээрийн олон улсын эрх зүйн хэм хэмжээ нь юуны өмнө тэдний үйл ажиллагааны хүрээн дэх дэлхийн улс төрийн болон тэдгээрийн хоорондын харилцааны бусад улс үндэстний өөр улс болон байгууллагуудтай харилцах хоорондын харилцааны тодорхой хүчин зүйлээс хамаарна.

Олон улсын шашны байгууллага, нэгдэл холбоод нь засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээр дээр үндэслэгдэж байгуулагддаггүй. Олон улсын харилцаанд ямар бодлого явуулах, өөр бусад улс орнууд, олон улсын байгууллагуудтай ямар хамтын ажиллагаа явуулах гэж буйгаас шалтгаалан тэдгээрийн олон улсын эрх зүйн ангилал нь тодорхойлогдоно.

Олон улсын шашны байгууллагууд, нэгдэл холбоод нь олон улсын харилцаанд зөвлөгчийн үүрэгтэй оролцдог ба НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд, мөн бүс нутгийн байгууллагууд болох Европын холбоо, Арабын улсуудын холбоо, Исламын Чуулганд зөвлөгч байр суурьтай оролцдог.

Олон улсын шашны байгууллага, нэгдэл холбоодын болон засгийн газрын бус олон улсын байгууллагуудыг адил төстэй эрх зүйн хэм хэмжээ ойртуулж өгдөг. бий болсон байна. үндсийг тодорхойлоод улсын засгийн газар бус байгууллагууд болон сүм хийдийн асуудал эрхэлсэн шашны байгууллага, мөн шашны бүлэг холбоо болон улс орны тусгай этгээд болон тэдэнтэй адил төстэй шашны нэгдэл холбоодын олон улсын эрх зүйн хэм хэмжээг ойртуулж өгдөг. Олон улсын харилцааны салбарт шашны байгууллагууд нь хяналт тавих, эрх зүйн хэм хэмжээ бий болгох, мэдээлэх, зөвлөх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна. Олон улсын шашны байгууллагууд энх тайвны салбарт олон улсын мөргөлдөөнийг зохицуулах, олон улсын харилцаанд итгэлцлийг бэхжүүлэх, олон улсын маргааныг эв зүйгээр шийдэхэд хэлэлцээр болон эвлэлдэн нэгдэх арга ажиллагааг авч хэрэгжүүлдэг болсон. Өөрийн түүхэн уламжлал ёсоор олон улсын шашны байгууллага нь шашны болон үндэсний цөөнх, хүүхдийн болон гэр бүлийн эрхийн асуудал болох хүний эрхийг хамгаалах салбарын гэрээ хэлэлцээрийн төсөлд санал оруулах, эрх зүйн хэм хэмжээг боловсронгуй болгох, сайжруулахад онцгой анхаарч ажилладаг. Шашны эрх, эрх чөлөөг баталгаажуулсан одоо үйлчилж буй олон улсын эрх зүйн гэрээ конвенциудын төсөл дээр Сүмийн дэлхийн холбоо чухал үүрэг гүйцэтгэсэн. Үүнд: 1948 оны Амстердамын чуулган, 1961 онд Делийн чуулган, 1965 оны Женевийн “сүм хийдийн хорооны олон улсын ажиллагааны тухай” олон улсын хурал болон Найробигийн 1975 оны Чуулганыг нэрлэж болно.

4. Үнэн алдартны сүм хийд

Үнэн алдартны шашин нь христос шашны эртний гол төлөөлөгчдийн нэг юм. Орчин үеийн үнэн алдартны шашинд (Дэлхийн үнэн алдартны сүм хийд) тодорхой нэгэн өөрийн төв гэж байдаггүй бөгөөд өөрийн 15 захиргааны байгууллагатай ба 4 бие даасан сүм хийдтэй. Есөн үнэн алдартны сүм хийдийг тэргүүн хамба, бусад сүм хийдийг нь ширээт лам болон хамбууд тус тус удирддаг.

Бүх сүм хийд нь ёс жаягийн гэж нэрлэгддэг бөгөөд өөрөөр хэлбэл хууль зүйн байр сууринаас сүм хийдийн уламжлал, эрх зүйн ёс жаягийг үйл ажиллагаандаа удирдлага болгодог.

Тэдгээрийн түүхэн гарал үүсэл, нэгдсэн сургууль болон сүм хийдийн түүхэн гарал үүсэл нь нэгэн адил байдаг. Мөргөлийн сургууль болон өмсгөл зэрэг уламжлалт ёс жаяг нь /хууль дүрэм нь/ дахин үүсч байгаа үнэн алдартны сүм хийд нь дарь эхийн зөвшөөрлийг баталгаажуулсан байх бөгөөд үүгээрээ сүм хийд нь ялгагдах ба мөн түүнчлэн ертөнцийн патриархын буюу хамгийн эртний үнэн алдартны шашны тэргүүлэгчдийн тусгайлсан тогтоолоор сүм хийдийн зөвшөөрлөө авсан байдаг. Ерөнхийдөө бүх үнэн алдартны шашны сүм хийдүүд нь ёс жаяг, дотоод хууль дүрмүүд болон түүн дотроо сүм хоорондын харилцаа бүх дэлхийн сүм хийдийн болон түүнчлэн Римийн эзэнт гүрний үеийн сүм хийдийн засаг захиргааны үндсэн хууль зүйн хэм хэмжээг дагаж мөрдсөн байдаг.

Оросын үнэн алдартны шашны ёс зүйн хэм хэмжээний анхны үндэс нь 12-13 -р зууны үеийн Иоанна Схоластика болон хамба лам Фотия нарын ном сургаалийн славян хэл дээрх орчуулга нь болж өгсөн. Оросод сүм хийдийн болон ёс зүйн эрхийн цувралууд нь Кормчихын ном хэмээх нэрийг авсан байдаг.